

СЭТГҮҮЛ ЗҮЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРИМ ОНЦЛОГ

Ж. Батбаатар*

* МУБИС-ийн Сэтгүүл зүйн тэнхмийн эрхлэгч, доктор (Ph.D), дэд профессор.

Түлхүүр үг: сэтгүүл зүйн хэл, бичлэг, найруулга, сэтгүүлчдийн ёс зүйн хэм хэмжээ, ур ухаан, бүтээлч чадвар, уран зохиолын төрөл.

Монголд чөлөөт хэвлэл, хэвлэлийн эрх чөлөө төлөвших явцад учирч буй бэрхшээлүүд болох хууль эрх зүйн таагүй орчин, хараат байдал, ашиг сонирхлын зөрчил зэргийн тухай бид олонтаа ярьж, шийдвэрлэх арга замыг байнга эрэлхийлж ирсэн. Үүний зэрэгцээ сэтгүүл зүйн мэргэжлийн үйл ажиллагааны дотоодод оршиж буй зарим асуудал, тэдгээрээс үүдсэн хүндрэл бэрхшээлд ч мөн адил анхаарлаа хандуулж, засан төгөлдөржүүлэх нь амжилтын нэг эх үндэс болох учиртай. Чухамхүү ийм зорилгоор тэдгээр асуудлын зөвхөн хоёрынх нь тухай хэвлэлийн зарим баримтад тулгуурлан цухасхан авч үзэж байна.

1. Сэтгүүл зүй бол мэргэжлийн өвөрмөц үйл ажиллагаа юм

Сэтгүүл зүй нь бидэнд цаг үе, нийгмийн амьдралын үйл явц, хэмнэл өөрчлөлтийг илэрхийлэх мэдээллийг цаг үргэлж хүргэж байдаг үйлчилгээний хэлбэр, түүнд зориулагдсан тогтолцоо юм.

Ардчилсан нийгэмд сэтгүүл зүй суртал ухуулгын хэрэгслэл, эсвэл олон нийтийн санаа бодлыг удирдан чиглүүлэх, нөлөөлөхөд бус, иргэдийн мэдээллийн эрхийг хангах бодит мэдээллийг хүргэж үйлчлэх нь л чухал билээ.

XIX зууны сүүлчээр хүчтэй дэлгэрсэн шар сэтгүүл зүй олон нийтийн дунд сонин хэвлэлийн тухай сөрөг уур амьсгал бий болгож, уншигчид хэвлэлд ихээхэн шүүмжлэлтэй хандах болсноор сэтгүүл зүй өөрийн үйл ажиллагаандаа тодорхой хэм хэмжээг баримтлах шаардлага чухлаар тавигдах болсон юм.

Чухам ийм шалтгаанаар хэвлэл мэдээлэл, сэтгүүлчдийн ёс зүйн хэм хэмжээ, үйл ажиллагааны үндсэн зарчмуудыг тодорхойлсон кодекс, баримт бичгүүдийг 1920-иод оны үеэс боловсруулан мөрдөж эхэлжээ. Сэтгүүлчдийн

нийгмийн өмнө хүлээх мэргэжлийн хариуцлага, түүнд нөлөөлөх ёс зүйн шалгууруудыг тусгасан “ёс зүйн анхны кодексуудыг баталсан нь сэтгүүл зүй мэргэжлийн үйл ажиллагааны өвөрмөц салбар болон бүрэн төлөвшсөний илрэл болсон”¹ юм.

Өнөөдөр олонх ХМХ мэргэжлийн үйл ажиллагааны баримтлах чиглэл, зарчмаа тодорхойлсон журам гарган мөрдлөг болгон ажиллах боллоо. Эдгээр “Орчин үеийн кодексуудад “эрх ашгийн зөрчил”-ийг зохицуулах буюу сэтгүүлчийн хувийн сонирхол болон мэргэжлийн ажлын сонирхлын (мэргэжлийн үүрэг, хариуцлага) хоорондох зөрчлийг арилгах асуудалд онцгой анхаарал тавьдаг болсон”² байна.

Гэтэл манай практикт үйл явдлыг хөндлөнгөөс харж, болсон зүйл, бодит баримтыг уншигчдад мэдээлэх, дамжуулах замаар тэдний эрх ашигт үйлчлэх ёстой мэдээний сэтгүүлчид ч мэргэжлийн үүрэг, ёс зүйгээ умартан хэрэг явдлын зөв бурууг шүүн тунгааж, үнэлэн дүгнэх, байр сууриа илэрхийлэх, үзэл бодлоо тулгах байдлаар уншигч, үзэгчдээ үл хүндэтгэх нь нийтлэг зүйл, бүр “үүрэг” нь мэт болсон байна.

Үүнийг зарим мэдээллийн хэрэгслийн баримтаар үзвэл илүү тодорхой болно.

Жишээ нь: “...ийнхүү өөрийн хүсэлтээр Засгийн газрын гишүүнээс огцрох өргөдлөө өгсөн эрэлхэг зоригт

сайд Одончимэдээр сэтгүүлч Алтаншагай бахархлаа” (TV8, “Толь” мэдээллийн хөтөлбөр, 2007.)

“...Дээр нэр дурдсан эрхмүүд бүгдээрээ дэвшихгүй нь лав. Тиймээс Баянзүрх дүүргийн МАХН-ын хорооны хурал нэлээд хэрүүл тэмцэлтэй болох нь тодорхой байна.” (МАХН-ын арваад хүн нэг тойрогт тунажээ, “Зууны шуудан”, №082, 2008)

“Өнөөдөр “Метрополис”-т болох тус клубийн “Мобиком”-той хамтран зохион байгуулж буй шоун дээр дуучин ВХ монголоор, Л. Шамман францаар мөнөөх “Миний хайр”-ыг хэрхэн дуулахыг сонирхож болох ажээ. Сонирхолтой нэгэн үйл явдал болох нь ээ.” (“Өдрийн сонин”, №035, 2008) зэрэг мэдээнд сэтгүүлч ёс зүйгээ зөрчиж, “баримтад халдан” өөрийн үнэлэмж, үзэл бодлыг оруулсан байгаа нь манай сэтгүүлчдийн гаргадаг нийтлэг дутагдлыг илэрхийлэх баримт юм.

Ерөөсөө бусад мэргэжлээс сэтгүүл зүйн ялгарах онцлог нь цаг хугацааны явцуу хүрээнд шийдвэр гаргах, сонголт хийх, мэдээлэл, баримтыг хувийн үзэл бодол, ашиг сонирхлоосоо зааглан хандах шаардлага байнга тулгарч байдаг оршино.

Сэтгүүлч аливаа нэг нам, улс төрийн байгууллагын гишүүн, хэсэг бүлгийн төлөөлөл байж, түүнийхээ эрх ашиг, үзэл санааг илэрхийлэгч бус, хэнээс ч үл хамаарах “завсрын бүс”-д

оршиж, тухайн асуудалд өөрийн хувийн үзэл бодол, байр суурь ямар байх, юу гэж үзэж байгаагаас үл шалтгаалан, гагцхүү уг үйл явдал, баримтыг л бодот байдлаар нь уншигч, хэрэглэгчдэд хүргэх нь бүхнээс эрхэм байдаг. Өөрөөр хэлбэл, сэтгүүлч өөрийн иргэний байр суурь, хувь хүний үзэл бодлоо баримт, мэдээллээс заагтай байлгаж чадсан тэр нөхцөлд л мэргэжлийн болон ёс зүйн үүрэг, хариуцлага, мэдээллийн бие даасан байдал нь жинхэнэ утгаараа хэрэгжиж байдаг онцлогтой юм.

II. Сэтгүүл зүй уран бүтээлийн шинжтэй үйл ажиллагаа болох нь

Сэтгүүл зүй урлагийн салбарт хамаардаггүй, түүний нэгэн төрөл болох уран зохиолоос ихээхэн ялгаатай хэдий ч сэтгүүл зүйн бичвэрүүд нь уран сайхны бичлэгийн төрлүүдийн нэг адил өөрийн бүтэц, олон бүрэлдэхүүн хэсгийг агуулсан тодорхой хэлбэр байж, тухайн агуулгад тохирох стиль хэв маягийг бүрдүүлэх ур ухаан, бүтээлч чадварыг зохиогчоос шаардаж байдаг утгаараа уран бүтээлийн шинжтэй үйл ажиллагаа юм.

Ийнхүү сэтгүүл зүйн хөдөлмөр цэвэр уран бүтээл бус боловч уран бүтээлийн хэв шинжийг хагас заримдаг байдлаар хадгалж байдаг нь түүний бас нэг өвөрмөц тал ажээ.

“Сонин бол уран зохиол биш. Сонинд материал бичих нь роман, эсвэл өгүүллэг бичихээс эрс өөр зүйл.

Гэхдээ зарим хүн энэ хоёрын хооронд нэг их ялгаа байхгүй гэж үздэг тал бий. Миний бодлоор энэ хоёр ажлын нийтлэг шинж нь аль алиныг дээд зэргээр сайн бичих явдал л юм”³ гэж судлаачид үзэх нь бий.

Уран зохиол, сэтгүүл зүй хоёрт зарим адил төсөөтэй шинж бий хэдий ч “Сэтгүүл зүй нь бүхэлдээ уран сайхны бус бичлэг бөгөөд чухамдаа “баримт, баримт, бас дахин баримт” гэсэн зарчимд тулгуурлан бүтдэг. Сэтгүүл зүйн бичлэгийн төрлүүд аливаа түүх, өнгөрсөн явдал, зохиомол зүйл, уран санаанаас ангид байх ёстой”⁴ гэж үздэг нь орчин цагийн сэтгүүл зүйн үүрэг, зорилгын үүднээс авч үзвэл зайлшгүй зүйл юм.

Учир нь баримт хэмээх хэн нэгний санаа бодол, үзэл хандлагаас хавьгүй үнэ цэнэтэй, халдашгүй зүйлд субъектив үзэл, сэтгэлийн хөдөлгөөний өнгө аяс нөлөөлөх нь бодот баримтыг гуйвуулах нэг нөхцөл болдог тул цэвэр сэтгүүл зүйн бичвэрт уран дүрслэл, хэлний яруу хэрэглүүр, тэр ч байтугай тодотгол, тэмдэг нэрийг хэтрүүлэн хэрэглэх зэрэг ямар нэг байдлаар уран сайханжуулах бүхий л хандлагаас мэргэжлийн сэтгүүл зүй ямагт зайлсхийж, ихэд болгоомжтой ханддаг.

Гэтэл манай сонинууд “*Намрын налгар өдрүүд айлчлан ирж, найр хуримын зар хаа сайгүй түгсээр. Шинэхэн цол авсан бөхчүүд найраа*

хийж, гал голомтоо бадраах хосууд хуримаа хийхээр хоног тоолон өдрийн сайныг хүлээж байхтай зэрэгцэн нэгэн “нүсэр” найрын зар түгж эхэллээ. Энэ сарын 28-нд “Баянгол” ресторанд болох хөлтэй найрыг Монгол Улсын гавьяат тамирчин арлын Японд сумо бөхөөр эх орныхоо нэрийг дуурсгаж буй 69 дэх их аварга Ёкозуно М.Даваажаргал хийх гэж байгаа аж” (“Хүмүүс” сонин, №36, 2007)

гэх мэтээр бичиж байна.

Харин цэвэр сэтгүүл зүйн бичвэр болох уг мэдээ ердөө л “Мэргэжлийн сумогийн 69 дэх их аварга М.Даваажаргал энэ сарын 28-ны өдөр Ёкозуно цолныхоо найрыг “Баянгол” ресторанд хийхээр товложээ” гэж байх нь зохистой юм.

Бас нэгэн жишээ: “Тэнгэр бүүдийж, гэгээ анирдсан амралтын өдрүүд улирлаа. Үе, үе салхи сэвэлзэж, хур буух нь уу гэлтэй чийг үнэртсэн эл өдрүүдийн цаг агаар ойрын хэд хоногтоо үргэлжилнэ гэж Ус, цаг уурын хүрээлэнгээс манайд мэдээллээ” (“Өнөөдөр”, 2008, №80) гэх мэтчилэн иргэдийн хэрэгцээт мэдээллээ авах зорилгоор уншдаг сонины мэдээ уран зохиолын төрөлтэй ялгахын аргагүй байдалд хүрч, уран дүрслэл, чимэг үг,

уянгалаг тансаг хэлээр голлон бүтэж, уг мэдээллийн зорилго, мөн чанарыг алдагдуулахад хүргэдэг ийм гажуудал, төөрөгдөл түгээмэл байна.

Сэтгүүл зүйн аль ч төрлийн бичвэрт уншигчийн сэтгэлийг хөдөлгөх үг, хэл найруулгаас илүү сэтгүүлчийн сонгон авч хүргэж буй уг үйл явдал, мэдээлэл нь тэдний анхаарал, сонирхлыг татахуйц, сонсож дуулаагүй шинэ

сэргэг, хэрэгцээтэй байх нь чухал бөгөөд уран зохиол, сэтгүүл зүй хоёрын хэл эрс ялгаатай.

Тиймээс хүн төрөлхтний сэтгүүл зүй урт удаан хөгжлийн явцдаа өөрийн гэсэн хэл, бичлэг, найруулгын тогтвортой хэв

маяг, арга техникийг нэгэнт бүрдүүлэн бий болгож чадсан атал бид тэрхүү ололтыг үл анзаарч, үл хэрэгсэх нь орчин цагийн сэтгүүл зүйн хөгжлийн эрх ашигт ихээхэн харш юм.

Одоогийн манай практикт хэвлэл мэдээллийн ажилтнууд, сэтгүүлчдийг уран бүтээлчид гэж нэрлэж (тухайлбал, ММ агентлагийн уран бүтээлчид, манай сонины уран бүтээлчид гэж ярьдаг нь сөрөг үр дагавартай. Харин цэвэр сэтгүүл зүйд үл хамаарах жанрууд, ялангуяа ихээхэн нийлэг шинжтэй телевизийн бүтээлийн бусад

«

Уран зохиол, сэтгүүл зүй хоёрт зарим адил төсөөтэй шинэс бий хэдий ч сэтгүүл зүй нь бүхэлдээ уран сайхны бус бичлэг бөгөөд чухамдаа “баримт, баримт, бас дахин баримт” гэсэн зарчимд тулгуурлан бүтдэг. Сэтгүүл зүйн бичлэгийн төрлүүд аливаа түүх, өнгөрсөн явдал, зохиомол зүйл, уран санаанаас ангид байх ёстой.

»

төрөл хэлбэрүүд үүнд мэдээж орохгүй. — Ж.Б.), ийнхүү хэвшсэн нь үнэн хэрэгтээ сэтгүүл зүйг урлаг, уран бүтээлтэй адилтгах, хольж хутгах, уран сайханжуулах үндэс суурийг бүрдүүлж өгч буй сэтгэл зүйн хүчин зүйл болохыг бид тэр бүр анзааралгүй явж иржээ.

Нийгэмд мэдээллийн эрэлт хэрэгцээ, үнэ цэн улам бүр өсөн нэмэгдэж байгаа энэ үед хэвлэл мэдээллийн тухай өмнөх нийгмээс улбаатай уламжлалт ойлголтоос ангижирч, ардчилсан шинэ нийгэм дэх сэтгүүл зүйн мөн чанар, үүрэг зориулалтыг сайтар танин мэдэж, хариуцлагаа ухамсарлаж, ёс зүйгээ чанд баримталж, өөрсдөдөө тавих шаардлагаа өндөрсгөн мэргэжлийн төвшинд ажиллах явдал нийт хэвлэл, сэтгүүлчдийн өмнө тулгамдаж байна.

Ишлэл

¹ Зулькафиль М., Чойсамба Ч. 2007. Америкийн сэтгүүл зүйн түүх. УБ. 123 дахь тал.

² Мөн тэнд.

³ Рэндалл Д. 2002. Яаж сайн сэтгүүлч болох вэ? (Орч. М.Зулькафиль). 7 дахь тал.

⁴ Батбаатар Ж. 2007. Сэтгүүл зүй. УБ. 30 дахь тал.

Ашигласан бүтээлийн жагсаалт

1. *Charity A.* 1995. *Doing Public Journalism.* New York.
2. *Fidler R.* 1997. *Understanding New Media.* California.
3. Батбаатар Ж. 2007. Сэтгүүл зүй. УБ.
4. Зулькафиль М., Чойсамба Ч. 2007. Америкийн сэтгүүл зүйн түүх. УБ.
5. Рэндалл Д. 2002. Яаж сайн сэтгүүлч болох вэ? (Орч. М.Зулькафиль). УБ.

Резюме

Как считает автор, существуют многочисленные упущения и недочёты, отрицательно сказывающие на качестве профессиональной деятельности журналистов. Основной причиной всего этого являются пренебрежительное отношение журналистов к своему долгу, к этическим ценностям, недостаточно высокое требование к самому себе.

Сегодня журналистика медленно, но верно трансформируется из информационной в описательно-развлекательную. Даже такой стрессовой и фундаментальный жанр как информационная заметка стал подаваться аудитории как литературный рассказ. Кроме того, наперекор всем этическим принципам, требующим отделять факты от субъективных мнений, журналисты всё более и более стали выдавать свои мнения как свершившийся факт. Всё это наносит непоправимый ущерб престижу журналистики как "четвёртой власти".